



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 17 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/53

Баянгол

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:
1. Биеийн тамир, спортын салбарын улсын нэг удаагийн үзлэг, тооллогыг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Х.Төртулга /Засаг даргын орлогч/

Гишүүд: Ч.Тогтохням /ЕБС-ийн Биеийн тамирын багш/

Н.Мөнхзул /ЕБС-ийн Нийгмийн ажилтан /

Г.Ган-Очир /Баянгол багийн Засаг дарга/

Ж.Эрдэнэлүүрэв /Хамтын хүч багийн Засаг дарга/

Ц.Даваадорж /Сондуулт багийн Засаг дарга /

Б.Гантулга /Улаантуг багийн Засаг дарга/

2. Биеийн тамир спортын салбарын улсын нэг удаагийн үзлэг тооллогыг чанартай зохион байгуулж тайланг нэгтгэн 2017 оны 12 дугаар сарын 15-ны дотор Биеийн тамир спортын газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Х.Төртулга/-д даалгасугай

3. Үзлэг тооллогын ажилд ач холбогдол өгч хариуцлагатай ажиллан тайланг хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Х.Төртулга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР



96

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 12 сарын 06 өдөрДугаар А/54

Баянгол

Хөрөнгө зарцуулах тухай

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу “Өрмөн шаргал говь”-2017 үзэсгэлэн худалдаа зохион байгуулж төрөл тус бүрд шалгарсан иргэдийг өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнасугай.

2. Улсын төрөлжсөн олимпиадад амжилттай оролцсон багш Э.Алтайбаатар, Д.Ууганцэцэг нарыг өргөмжлөл, мөнгөн шагналаар, Оюуны өмч улсын бүртгэлийн газрын 77 жилийн ойг тохиолдуулан улсын бүртгэгч Г.Гантулгыг өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнасугай.

3. Үзэсгэлэн худалдааны мөнгөн шагналд 310000 төгрөг, багш нарын шагналд 90000 төгрөг, Г.Гантулгын шагналд 60000 төгрөг, нийт 460000 төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөнөөс зарцуулахыг Төрийн сангийн төлөөлөгч Н.Ганзориг, ня-бо Л.Оюунбилэг нарт зөвшөөрсүгэй.

4. Холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлэн санхүүтэй тооцоо хийхийг нярав /Б.Уранцэцэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 12 сарын 19 өдөр

Дугаар #155

Баянгол

Хөрөнгө зарцуулах тухай

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 04/01 тоот тогтоол, Засаг даргын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017 оны ажил үйлсээрээ байгууллага хамт олноо манлайлсан оны шилдэг 9 алдартанг цом, дурсгалын зүйлээр, сумын бүтээн байгуулалтанд үнэтэй хувь нэмэр оруулсан, мал аж ахуйн салбарт амжилт гаргасан нэр бүхий 10 иргэнийг өргөмжлөл, дурсгалын зүйлээр тус тус шагнасугай.

2. Тэмээн сүргийн тогтвортой өсөлтийг хангах, ашиг шимийг нэмэгдүүлэх, үүлдэр угсааг сайжруулах зорилгоор “Тэмээн сүргийн говь”-2017 тэмээний баярыг зохион байгуулсугай.

3. Оны шилдгүүдийн шагналд 360000 төгрөг, хамт олноо манлайлсан нэр бүхий 10 иргэний шагналд 300000 төгрөг, “Тэмээн сүргийн говь”-2017 тэмээний баярын шагналд 520000 төгрөг, нийт 1180000 төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөнөөс зарцуулахыг Төрийн сангийн төлөөлөгч Н.Ганзориг, ня-бо Л.Оюунбилэг нарт зөвшөөрсүгэй.

4. Холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлэн санхүүтэй тооцоо хийхийг нярав /Б.Уранцэцэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГАТАМИР



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 12 сарын 26 өдөр

Дугаар A/56

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, 29.1.3 "А" дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төл малын мялзан өвчний урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдаагүй үлдсэн Хамтын хүч багийн нэр бүхий өрхөд байгаа төлийг вакцинжуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: Б.Гантулга / МЭҮТ-ийн байцаагч /

Гишүүд: Ж.Эрдэнэпүрэв /Багийн Засаг дарга/

Х.Баатаржаргал /Багийн ИНХ-ын дарга/

2. Тарилгын зар тараах, үлдсэн төлийн хамрагдалт, вакцины тарилтын технологид хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга /Ж.Эрдэнэпүрэв/-д үүрэг болгосугай.

3. Вакциныг өөрөө тарьж, тайланг холбогдох баримтын хамт Хүнс хөдөө аж ахуйн газарт 12 дугаар сарын 30-ны дотор хүргүүлэхийг МЭҮТ-ийн улсын байцаагч /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

4. Малчдад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж, зарцуулагдах шатахууны зардлыг буруутай этгээдээр төлүүлэхийг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Х.ТӨРТУЛГА





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/57

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийг хамарсан ажлын санхүүжилтээр хийгдсэн “Мал нядлах цэг”-ийн хог цэвэрлэгээний ажлын гүйцэтгэлийг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: Х.Даваацэрэн / МЭҮТ-ийн дарга /

Гишүүд: Б.Гантулга /МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Г.Ган-Очир /Багийн Засаг дарга/

2. Ажлын гүйцэтгэлийг хүлээж авсан акт тэмдэглэлийг үйлдэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ОРЛОГЧ  Х.ТӨРТУЛГА





**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 17 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/58

Баянгол

Нийтээр амрах баяр ёслолын өдрүүдэд авах арга хэмжээний тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.1.6-ын "л", 29.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ жилийн баяр ёслолын өдрүүдэд ажиллах сумын хариуцлагатай эргүүл, жижүүрийн нэр, ажиллах өдөр, цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.
2. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрүүдэд архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг хориглосугай.
3. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн халаалт, хаалга цонхны бүрэн бүтэн байдал, галч жижүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
4. Цаг агаарын болзошгүй аюулт үзэгдлийн сэрэмжлүүлэг мэдээг цаг алдалгүй сумын удирдлага, багийн Засаг дарга, иргэд, малчдад хүргэхийг цаг уурын ажиглагч /Г.Болормаа/-д даалгасугай.
5. Эргүүл жижүүрийг нэгдсэн удирдлагаар хангаж, архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгүүдэд хяналт тавьж ажиллахыг хэсгийн төлөөлөгч /Т.Гэндэнсүрэн/-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Х.ТӨРТУЛГА



Сумын Засаг даргын 20~~17~~¹⁸ оны ~~12~~¹² дугаар сарын ~~27~~²⁷-ны өдрийн ~~48~~⁴⁸ дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



Д/д	Жижүүрийн нэр	Албан тушаал	Ажиллах өдөр	Ажиллах цаг	Хариуцах албан тушаалтан
1.	Х.Даваацэрэн Д.Алтайбаатар	МЭҮТ-ийн дарга Ня-бо	12 сарын 29	09 ⁰⁰ –с 24 цаг	Т.Гэндэнсүрэн Ж.Сайнбилэг
2.	М.Золбаяр Г.Гантулга	Сургуулийн захирал Улсын бүртгэгч	12 сарын 30	09 ⁰⁰ –с 24 цаг	
3.	Б.Шинэхүү Г.Өлзийсайхан	Байгаль хамгаалагч ХХҮ-ний мэргэжилтэн	12 сарын 31	09 ⁰⁰ –с 24 цаг	
4.	А.Болдбаатар Б.Гантулга	Соёлын төвийн мэргэжилтэн МЭҮТ-ийн мэргэжилтэн	01 сарын 01	09 ⁰⁰ –с 24 цаг	



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/59

Баянгол

Газар эзэмшүүлэх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Улаантуг багт газар тариалангийн зориулалтаар хүсэлт гаргасан 2 га газрыг Гүцээ овогтой Чогдон, Дамба овогтой Нармандах нарт 2 жилийн хугацаатай Тэмээн хүзүүний голд эзэмшүүлсүгэй.

2. Иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээжүүлэхийг газрын даамал /Б.Гэрэлт-Од/-д даалгасугай.

3. Гэрээний үүргийн хэрэгжилтийг ханган ажиллахыг газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 17 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/60

Баянгол

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сондуулт багийн Далан Ээвд “Гүнзэгэстэй”ХХК-д шатахуун түгээх станц барих зориулалтаар 3 га газрыг 2 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулан гэрчилгээжүүлэхийг газрын даамал /Б.Гэрэлт-Од/-д даалгасугай.
3. Гэрээний үүргийн хэрэгжилтийг ханган эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 17 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/61

Баянгол

**Иргэнд эзэмшиж байгаа газрыг
үнэгүй өмчлүүлэх тухай**

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2.8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эзэмшиж байгаа газраа хуулийн дагуу өмчлөхийг хүссэн нэр бүхий 3 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг нь өмчлүүлсүгэй.
2. Гэр бүлийн хэрэгцээнд газраа өмчилж авсан иргэнд өмчилсөн газрын кадастрын зургийг гаргаж, өмчлөх эрхийг Улсын бүртгэлд бүртгэж, баталгаажуулан гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг газрын даамал /Б.Гэрэлт-Од/-д үүрэг болгосугай.
3. Өмчлөх эрхээ холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажуулж, өмчилж авсан газартаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хугацаанд нь хийлгэж байхыг газар өмчилж авсан иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

105
Сумын Засаг даргын 2017 оны 12
дугаар сарын 28-ны өдрийн 1/61
дугаар захирамжийн хавсралт

№	Овог, нэр	газрын		
		зориулалт	хэмжээ /м ² /	байршил
1.	Өрөгийн Сугар	Гэр бүлийн хэрэгцээ	700	Шанд хороолол 2-8 тоот
2.	Бадарчийн Батбаяр	Гэр бүлийн хэрэгцээ	700	Шанд хороолол 4-2 тоот
3.	Бямбын Доржгарав	Гэр бүлийн хэрэгцээ	700	Шанд хороолол 5-1 тоот



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 17 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/62

Баянгол

Газар эзэмшүүлэх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Баянгол, Хамтын хүч, Сондуулт, Улаан туг багт өвөлжөө, хаваржааны зориулалтаар нэр бүхий 22 иргэнд 2 жилийн хугацаатай газар эзэмшүүлсүгэй.
2. Иргэдтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээжүүлэхийг газрын даамал /Б.Гэрэлт-Од/-д даалгасугай.
3. Гэрээний үүргийн хэрэгжилтийг ханган ажиллахыг газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР



107

Сумын Засаг даргын 2017 оны
12 дугаар сарын 28 ны өдрийн
162 дугаар захирамжийн хавсралт

	Овог нэр	Газрын		
		зориулалт	Хэмжээ /м ² /	байршил
1.	Даваагийн Өлзийбат	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Устын сайр
2.	Үрчээний Даваа	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Улаан хавцгайн эх
3.	Цэцэгмаагийн Сүхбат	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Зост
4.	Гүрийн Баянмөнх	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Мөст
5.	Банзарын Дашмягмар	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Шанд
6.	Сундуйн Дамдиндаваа	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Түлэнхий буудал
7.	Ядамхүүгийн Доньдсүрэн	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Чулуун хороот
8.	Пүрэвдоржийн Энхбаатар	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Барзан улаан
9.	Банзарын Нямдорж	Өвөлжөө	2000	Хамтын хүч багийн Өвдгийн мөрөг
10.	Сугарын Дашцэрэн	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Ногоон таананы урд буудал
11.	Базаррагчаагийн Батсайхан	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Ногоон таананы доод буудал
12.	Дуламсүрэнгийн Алтаншагай	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Янхир
13.	Базаррагчаагийн Батсайхан	Хаваржаа	2000	Хамтын хүч багийн Улаан хавцгайн ам
14.	Намжилын Батбаяр	Өвөлжөө	2000	Улаантуг багийн Хонхор бууц
15.	Доржийн Гаадансүрэн	Өвөлжөө	2000	Улаантуг багийн Цагаан асга
16.	Баттөмөрийн Очирсүрэн	Өвөлжөө	2000	Улаантуг багийн Наруул
17.	Бариадын Баясгалан	Өвөлжөө	2000	Улаантуг багийн Доод алаг морьт
18.	Сүрэнхорын Алтансүх	Хаваржаа	2000	Баянгол багийн Харганат
19.	Дашийн Баттөр	Хаваржаа	2000	Баянгол багийн Ямбатын доод хашаа
20.	Содномын Тогт	Хаваржаа	2000	Баянгол багийн Булгийн адаг
21.	Хуяг-Очирын Бадрах	Өвөлжөө	2000	Сондуулт багийн Хүүш
22.	Хадбаасангийн Чимэд-Очир	Өвөлжөө	2000	Сондуулт багийн Дааган дэлийн оройн өтөг